

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2025.12. 10.

Улаанбаатар хот

Дугаар №04\ 2025

Ноос угаах тоног төхөөрөмж
худалдан авах тухай

“Стандарт ноос” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны урьдчилсан үр дүн, 2026 оны хөрөнгө оруулалтын үндсэн зорилтыг хэлэлцэн Компанийн тухай хуулийн 76.1., 76.1.16., 81.4.4 болон “Стандарт ноос” ХК-ийн Дүрмийн 7.30.1., 7.30.2., 7.45.5 дугаар заалтуудыг үндэслэн **ТОГТООХ НЬ :**

1. ТУЗ-өөс гаргасан ноос угаах тоног төхөөрөмжийн зах зээлийн үнийн судалгаанд үндэслэн “Стандарт ноос” ХК-ийн 2026 оны үйл ажиллагааны ерөнхий чиглэлд тусгагдсан ноос угаах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх 422,1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг дэмжин баталсугай.
2. “Стандарт ноос” ХК-ийн ноос угаах шугамын хүчин чадлыг нэмэгдүүлэн шинэчлэхэд БНХАУ-аас ноос угаах техник, тоног төхөөрөмж худалдан авах гэрээ хийхийг компанийн гүйцэтгэх удирдлага \ гүйцэтгэх захирал Б.Баасанбат\ -д зөвшөөрсүгэй.
3. Үйлдвэрийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын санхүүжилтэнд шаардагдах хямд эх үүсвэрийг төр, хувийн хэвшлийн банк, санхүү болон бусад зээлийн үүсвэрээр хангаж ажиллахыг компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагад даалгасугай.
4. Стандарт ноос компанийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтэнд хууль, журмын дагуу хяналт тавьж ажиллахыг компанийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо \ дарга Б.Баясгалан \ -д үүрэг болгосугай.



Ц.ЗОРИГТ

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2025.12.10.

Улаанбаатар хот

Дугаар №05\ 2025

Хөрөнгө оруулалтын зээл авах
тухай

“Стандарт ноос” ХК-ийн 2026 оны хөрөнгө оруулалтаар ноос угаах тоног төхөөрөмж худалдан авах тухай ТУЗ-ийн №04\ 2025 тоот тогтоолыг хэрэгжүүлж, Компанийн тухай хуулийн 76.1., 76.1.17., 89.1., 92.1., 92.5., 81.4.4 болон “Стандарт ноос” ХК-ийн Дүрмийн холбогдох заалтуудыг үндэслэн **ТОГТООХ НЬ** :

1. “Стандарт ноос” ХК-ийн 2026 оны хөрөнгө оруулалтанд шаардагдах 422,1 сая төгрөгийн зээлийг банк, санхүүгийн байгууллагын зээлийн зах зээлийн дундаж хүүнээс ихгүй хүүтэйгээр, 3 жил хүртэл хугацаатай, эргэн төлөгдөх нөхцөлтөйгөөр Компанийн хуулийн дагуу сонирхлын зөрчил бүхий этгээдэд тооцогдох “Стандарт ноос” ХК-ийн ТУЗ-ийн дарга Цоодолын Зоригтой зээлийн гэрээ хийхийг “Стандарт ноос” ХК-ийн гүйцэтгэх удирдлага \ гүйцэтгэх захирал Б.Баасанбат\ -д зөвшөөрсүгэй.
2. Стандарт ноос компанийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтэнд хууль, журмын дагуу хяналт тавьж ажиллахыг компанийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо \ дарга Б.Баясгалан \ -д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЗОРИГТ